

MICC ТЭМДЭГЛЭЛ

MICC.mn

2012 ОНЫ 5 ДУГААР САРЫН 24 (13)

14 хоног тутам гарна

MONGOLIA INTERNATIONAL CAPITAL CORPORATION — Монголын тэргүүлэх хөрөнгө оруулалтын банк

ЗАХ ЗЭЭЛИЙН ТОВЧ МЭДЭЭ


- УИХ стратегийн салбар дахь гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах хуулийг баталлаа.
- Монголын анхны олон улсын сериал дугаартай төрийн бонд энэ сарын 15-нд хоёрдагч зах зээлд арилжаалагдаж эхэллээ.
- Алтайн Хүдэр төмрийн хүдрийн компани 300 сая долларын IPO-г энэ оны 4 дүгээр улиралд Хонг Конгийн бирж дээр хийхээр төлөвлөж байна.
- Ivanhoe Mines нэрээ Оюу Толгойн англи орчуулга буюу *Turquoise Hill Resources* болгох тухай саналыг хувьцаа эзэмшигчиддээ тавьжээ. Мөн Оюу Толгойгоос бусад төслүүдээ зарж, Рио Тинто тус компанийг бүрмөсөн худалдаж авахад бэлдэж байна.
- Овоот Толгойн тусгай зөвшөөрлийг хурааж авах албан бичиг *SouthGobi Sands* компани дээр ирээгүй тул үйл ажиллагаагаа үргэлжлүүлж байгаа ч нүүрсийг худалдан авах захиалга нь багасч байгаа ажээ.
- Энэтхэгийн төрийн өмчит ган үйлдвэрлэгч компани Монгол улсын Засгийн газартай хамтран ажиллах гэрээ байгууллаа.
- MCS болон МАК нүүрсээс шингэн түлш боловсруулах үйлдвэрийг Сод Монгол Групп-тай хамтран байгуулж, 2016 онд ашиглалтанд оруулах төлөвлөгөөгөө зарлалаа.
- Хаан Банк Голландын Хөгжлийн Санхүүгийн компани тэргүүтэй банкуудаас нийт 94 сая ам.долларын 5 жилийн хугацаатай зээлийг авлаа.
- Centerra Gold 2012 оны 1 дүгээр улиралд 14.7 сая ам.долларын алдагдалтай ажиллажээ.

Еврогийн хямрал ба түүхий эдийн үнэ


Б. Ачболд



ЕВРОГИЙН БҮСИЙН ХЯМРАЛЫН тухай бид хамгийн Эсүүлд (3 дугаар сарын 15-нд) бичиж байхад Итали, Испанийн бондын хүү уначихсан, түүхий эдийн үнэ өссөн, хямрал намдах аястай байсан билээ. Харин хоёр сар гаруй хугацааны дараа “Грек Еврогоос гарах уу? Еврогийн бүс бутрах уу?” гэх мэт яриа өрнөж байна. Гэхдээ энэ бол шинэ яриа биш юм. Энэ тухай бид ч өмнө нь ярьж байсан. Үнэндээ ноднин жилээс хойш Еврогийн бүс дорвитой өөрчлөлт гарсангүй. Европын удирдлагууд уулзах болгонд хямралыг



ЗАХ ЗЭЭЛИЙН ТОДРУУЛГА



бүрмөсөн шийдвэрлэх болов уу гэсэн найдвар төрдөг ч энэ нь удалгүй замхардаг. Энэ удаагийн уулзалтаар ч мөн хямралыг эцэслэх хэмжээний шийдвэр гарсангүй. Герман “Грек зарлагаа багасгах хэрэгтэй” гэсэн хатуу байр сууриасаа хөдөлсөнгүй. Энэ мэтээр бол Грек удахгүй Еврогоос гарч болох юм. Тиймээс ч Европын удирдагчид Грек Еврогоос гарахад юу хийхээ төлөвлөөд эхэлжээ.

Гарсан тохиолдолд юу болохыг тааж мэдэхэд хэцүү. Сайнаар бодвол Европын удирдлагууд нэгийг ухаарч, Еврогийн бонд гаргах мэтээр хямралыг зогсоож болно. Грек Еврогоос гарсан ч энэ үйл явц нь төлөвлөгөөний дагуу, хүмүүсийн удирдлаган дор явагдана. Муугаар бодвол Грек ямар ч удирдлагагүйгээр, эмх замбараагүй байдлаар дампуурч (жишээ нь нэг өдөр хүмүүс сандарч мөнгөө нэг дор татаж), хүмүүсийн айгаад байгаа санхүүгийн “халдвар” тархаж болно. Грекийн эдийн засаг Еврогийн бүсийн эдийн засагтай харьцуулахад маш жижигхэн ч хэрвээ Грек Еврог хаяж бүрмөсөн дампуурвал Португал, Испани гэх мэтийн бусад улсууд Грекийг дагах болов уу гэж хөрөнгө оруулагчид айж эхэлнэ. Энэ нь тус улсуудын бондын хүүг өсгөж, айсан зүйл нь биелэх магадлал нь нэмэгдэнэ. *Wall Street Journal*-ын мэдээлснээр бонд худалдаж авдаг зарим сангууд саяхнаас Грек, Италийн бондуудаа зараад эхэлчихсэн бөгөөд оронд нь Америкийн бонд авч байна.

Еврогийн бүсийн хямрал түүхий эдийн үнийг бууруулах замаар Монголд нөлөөлж байна. Нүүр хуудаснаас сүүлийн үед алт, зэсийн үнэ хэрхэн унасныг харж болно. Зэсийн үнэ гэхэд л 4 дүгээр сарын эхнээс 10 орчим хувиар унажээ. *МИСС Уул Уурхайн Индекс* 4 дүгээр сарын эхнээс 32 хувиар унасан бөгөөд энэ нь тодорхой хэмжээгээр Еврогийн бүсийн хямрал, түүхий эдийн үнэ унаж байгаатай холбоотой юм. (Мөн Хятадын эдийн засгийн зарим үзүүлэлтүүд муу гарсан, стратегийн хөрөнгө оруулалтын тухай шинэ хууль гарсан явдлууд нь Индекс унахад нөлөөлсөн гэж бид



үзэж байна. Жишээ нь индексийн томоохон хэсгийг бүрдүүлдэг *Ivanhoe Mines* компанийн хувьцаа Монголд болж буй үйл явдлуудаас болж нилээдгүй унасан.)

Хөрөнгийн зах зээл хэрхэн хэлбэлздэгийг, ирээдүйг тааж мэдэх ямар амаргүй болохыг бид харж байна. Хэзээ нэгэн цагт Еврогийн хямрал дуусч, хөрөнгийн зах зээл сэргэнэ. Харин яг хэзээ, ямар байдлаар хямрал дуусах вэ гэдэг бол маш чухал асуулт юм. ☸

ЭДИЙН ЗАСАГ ЗУРГААР

Үнийн өсөлт сонгуулийн жилд




Хэрэглээний үнийн жилийн өсөлт

МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН гол асуудлуудын нэг бол үнийн өсөлт гэдэгтэй ихэнх хүмүүс санал нийлэх байх. Нэрт эдийн засагч Кейнс, “Нийгмийг эвдэх хамгийн зальтай, гэхдээ найдвартай арга бол мөнгөн тэмдэгтийг нь эвдэх [өөрөөр хэлбэл үнийн өсөлтөөр мөнгөн тэмдэгтийн үнэ цэнийг нь алдагдуулах]” гэжээ. Бид ч өмнөх дугаарууддаа үнийн өсөлтийн хор уршгийн тухай бичиж байсан.

2011 онд үнийн өсөлт 10.2 хувьтай байсан бол энэ онд 20 хувь давах төлөвтэй байна. Оны эхний дөрвөн сард хэрэглээний бараа үйлчилгээний үнэ улс даяар дунджаар 8.4 хувиар өсчээ. Зөвхөн нэгдүгээр сард л гэхэд 2.8 хувиар өссөн нь барууны орнуудын бүтэн жилийн үнийн өсөлттэй адил юм.

Монгол Улсын Хэрэглээний Үнийн Өсөлт



Үнийн өсөлтөд хоорондоо уялдаа холбоотой хэд хэдэн шалтгаан байдаг. Эдийн засгийн өсөлт их байгаа болохоор хүмүүсийн дундаж орлого нэмэгдэж, дагаад дотоодын эрэлт ихсэж байна. Эрэлт их байвал бизнесүүд үнээ нэмдэг жамтай. Энэ үзэгдлийг хүмүүс эдийн засгийн “халалт” гэж нэрлэдэг. Эдийн засгийг “халаах” хэд хэдэн хүчин зүйлүүд өнөөдөр Монголд үйлчилж


байна: Нэгдүгээрт бидний дээр дурдсан эдийн засгийн өсөлт орно. Эдийн засаг хурдтай өсч байгаагийн гол шалтгаан бол мэдээж уул уурхайн салбарт орж ирж буй гадаадын хөрөнгө оруулалт. (Тэгэхээр Оюу Толгой хүртэл үнийн өсөлттэй холбоотой!)

Хоёрт, нийгмийн халамж нэмэгдвэл дотоодын эрэлт бас нэмэгдэнэ. Гэхдээ нийгмийн халамжийг яаж санхүүжүүлж байгааг авч үзэх хэрэгтэй. Хэрвээ мөнгийг татварын орлогоос гаргавал (нэг ёсондоо баян хүмүүсээс авбал) эдийн засаг ингэж халахгүй. Харин (жишээ нь) Таван Толгойн бодит орлого орж ирээгүй байхад хүмүүст мөнгө хэвлэж тараавал эдийн засаг халж үнэ өсөх нь ойлгомжтой юм. Зөвхөн нийт мөнгөний хэмжээ л урт хугацаанд үнийн өсөлттэй шууд холбоотой байдаг.

Гуравт, импортын бараа бүтээгдэхүүний (жишээ нь газрын тосны) үнэ нэмэгдвэл дотоодын үнэ өснө.

Дөрөвт, өөр ямар нэгэн үйл явдлаас болж дотоодын эрэлт нэмэгдэж болно. Үүний гол жишээ бол сонгууль. УИХ-ын сонгуулиар харьцангуй их мөнгө зарлагддаг (бэлэг сэлт, “шоу” хүлээн авалт, реклам сурталчилгаа). Тиймээс ч 2012 онд эдийн засаг улам их “халах,” төгрөг үнэ цэнээ улам алдах аюул байна.

Үнийн өсөлтийн хэлбэлзэл буюу савлагаа бас их хор уршигтай байдаг. Жишээ нь хүмүүс ирэх жилд үнэ хэдэн хувиар өсөхийг тааж мэдэхгүй болохоор энэ жил хэр их хөрөнгө оруулахаа оновчтой төлөвлөж чаддаггүй. Бидний үзэж байгаагаар үнийн өсөлтийг удирдлагандаа авч эдийн засгийн бодит өсөлтийн хувиас дээш гаргахгүй байх нь манай Засгийн газрын эдийн засгийн бодлогын нэг чухал хэсэг байх ёстой. ❁



MICC

Mongolia's Investment Bank

THIS IS THE MICC JOURNAL, A BI-MONTHLY FINANCE AND ECONOMICS PAPER PUBLISHED BY MICC, THE LEADING INVESTMENT BANK IN MONGOLIA.

МIСС хөрөнгө оруулалтын банкны тухай
МIСС нь компанийн санхүүжилт, үнэт цаасны арилжаа, судалгаа, хөрөнгийн удирдлага зэрэг цогц үйлчилгээг дотоод гадаадын харилцагчиддаа санал болгодог Монголын ууган хөрөнгө оруулалтын банк юм.

МIСС ТЭМДЭГЛЭЛ – ийн тухай
Хоёр долоо хоног болгон гарах энэ бяцхан сонин танд эдийн засаг, санхүүгийн мэдээлэл өгөх боловч хөрөнгө оруулалтын зөвлөгөө өгөхгүй.

Таны эрсдэл таны хариуцлага.

Эрхлэгч: Б. Ачболд.

2012/5/24

Мэдээллийн эх сурвалж:
Bloomberg, Монголын
Хөрөнгийн Бирж.